



## ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дүгээр сарын  
24- ны өдөр

Дугаар 01.20

Улаанбаатар хот

**Тооллогын комиссын дарга Ч.Энхцэцэг:** Ээлжит ХЭХ-д хувьцаа эзэмшигчдийн 2025283 санал буюу 58,2% нь биеэр, 861711 санал буюу 24.7%-нь саналын хуудсаар, нийт 2886994 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид буюу 82.9%-ийн иртэйгээр оролцосноор Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан хүчинтэй ирцид хүрснийг хуралд мэдээлэв

Хурлын ирцийг мэдээлсний дараа хурлын дарга Д.Мөнхбат хурлын ажиллагааг эхлүүлээ.

**Д.Мөнхбат-** Цаг үеийн онцгой дэглэмийн нөхцөл байдлаас саналын хуудсаар хуралд оролцож байгаа болон биеэр хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг эрж, мэндчилье. ХЭХ-ын ирц хүчинтэй ирцид хүрсэн тул хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье.

Энэ удаагийн ээтжит хурлаар:

1. “Ариг гал” ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайлан. Илтгэгч нь: Гүйцэтгэх захирал Х.Хания (15 мин)
  2. “Ариг гал” ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулах. Илтгэгч нь: ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Д.Гиваапил (10 мин)
  3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох талаар нэр дэвшигчдийг танилцуулах. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг ТУЗ-ийн н.б.д Л.Нямжав (15 мин)
  4. Компанийн 2019 оны ашгаас Ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлэх ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (10 мин)
  5. Компанийн удирдлагын 2020 оны зардлын төсөвийг танилцуулах, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (10 мин)
  6. Компанийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулах ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав (15 мин)
  7. Хурлаар хэлэлцэх асуудлаар санал шүүмжлэл асуулт хариулт явуулах хугацааг хүн тус бүрт 3 мин-аар тогтоох,
  8. Хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар санал хураалт явуулах, дүнг ХЭХ-д танилцуулах (Тооллогын комиссын дарга Ч.Энхцэцэг 30мин)
  9. Хурлаас гарсан шийдвэрийг хэлэлцүүлж батлуулах. Хурлын дарга Д.Мөнхбат (цаг тогтоохгүй)
- Хурал хуралдуулах нийт хугацааг 1.30 цагаар тогтоох саналыг ХЭХ—д оруулж ил саналын 100%-ийн саналаар хурлын дэгийг батлууллаа.

**Хэлэлцсэн нь: Д.Мөнхбат-** Хэлэлцэх асуудлын дарааллаар ГЗ-ын тайлан сонсоё

**1. Х.Хания** Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Уламжлал ёсоор “Ариг гал” ХК –ийн хувьцаа эзэмшигчиддээ, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс, өнгөрсөн хурлаас хойш хийсэн ажил, тавьсан зорилгоо хэрхэн хэрэгжүүлснээ өнөөдөр тайлагнаж байна.

Тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас өмнөх хурлаар дэвшүүлсэн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан явуулж, “Ариг гал” группийн харъяа компаниудын дүнгээр 43.1 тэрбум төгрөгийн орлоготой, 591,3 сая төгрөгийн ашигтай ажиллаж, үйлдвэрлэлд 813.0 сая төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байрыг бий болгож, Улсын төсөвт 4.0 тэрбум гаруй төгрөгийн татвар шимтгэлийн орлого төвлөрүүлж, группийн хэмжээгээр өмнөх оноос орлого 1.7%-иар, хөрөнгө оруулалт 5.2%-иар, улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө 12.5 %-иар өслөө.

**Нэг. Борлуулалтын орлогын талаар**

Манай компани өнгөрсөн онд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2019 онд 2,415.0 сая төгрөгийн орлоготой байхаар төлөвлөсөнөөс 1,994.2 сая төгрөг буюу төлөвлөсөнөөс 17,4%-

иар өмнөх оны гүйцэтгэлээс 40%-иар орлого буурсан байна. Орлого буурсан гол нөлөөлөл нь хувьцаагаар оруулсан хөрөнгө оруулалтын ногдол ашиг буурсантай холбоотой. Мөн түрээсийн орлого 335,8 сая төгрөгт хүрч төлөвлөсөнөөс 16 %, өмнөх оноос 13 %-иар, ногдол ашгийн орлого 1,6 тэрбум төгрөг буюу төлөвлөсөнөөс 18%-иар буурсан биелэлттэй байна. 2019 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

|   | ҮЗҮҮЛЭЛТ                 | 2018 оны    |             | 2019 оны    |             | 2020 оны    |
|---|--------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
|   |                          | төлөвлөлт   | гүйцэтгэл   | төлөвлөлт   | гүйцэтгэл   | төлөвлөлт   |
| I | Борлуулалтын орлого      | 2,315,000.0 | 5,017,185.4 | 2,415,000.0 | 1,994,327.9 | 1,715,000.0 |
| 1 | Түрээсийн орлого         | 300,000.0   | 386,294.8   | 400,000.0   | 335,843.3   | 400,000.0   |
| 2 | Бараа борлуулсаны орлого | -           | -           | -           | -           | -           |
| 3 | Бусад орлого             | 2,015,000.0 | 4,630,890.6 | 2,015,000.0 | 1,658,484.1 | 1,305,000.0 |

#### Хоёр. Санхүүгийн байдлын талаар

2019 оны тайлан балансыг харахад үйл ажиллагааны зардлаа 724.1 сая төгрөгөөр буюу 49%-иар багасгасан. Үүний гол шалтгаан нь зээлийн хүүгийн зардал 638.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 22.5 сая төгрөгөөр, мөн цалингийн зардал 15,1 сая төгрөгөөр тус тус бууруулсан, харин ашиглалтын зардал 8,0 сая төгрөг, НДШ зардал 10,5 сая төгрөг өссөн байгаа.

Санхүүгийн тайлан балансаас харахад өнгөрсөн 2019 онд төлөвлөсөн зардлаас 57,5%-иар бууруулсан нь зардлаа хэмнэх бодлого явуулсан нь харагдаж байгаа. Ногдол ашгийн орлого 1,6 тэрбум төгрөг орж ирснийг охин компани болох Кашмер холдинг ХХК-д түүхий эдийн санхүүжилтанд олгосон гээд Балансын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг танилцуулав.

Ариг гал ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 266,1 сая төгрөгийн татвар шимтгэл төлсөн.

Үүнд: НӨАТатварт -10,2 сая төгрөг,  
НДШимтгэлд -62,4 сая.төгрөг,  
Газрын төлбөрт -120,6 сая төгрөг,  
ҮХХТатварт -43,0 сая төгрөг,  
ХАОАТатварт -29,5 сая төгрөг,  
ААНОАТатварт-0,8 сая төгрөг тус тус төлсөн байгаа.

#### Гурав. Өнгөрсөн оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт нь дараах биелэлттэй гарлаа.

Ариг гал ХК нь хөрөнгө оруулалттай охин компаниудын болон хувьцаагаар хирлэн оруулалттай компанийнхаа бүхий л үйл ажиллагааг дэмжин ажиллах, нөхцлийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, түүхий эд авах, жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулах, бизнес төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгож үл хөдлөх хөрөнгө, газраа барьцаалж зээл авах нөхцлийг бүрдүүлсэн.

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн компанийн ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 200 хүүхдийн цэцэрлэгийн ажиллагааг жигдрүүлэх, ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарал тавьж, дотоод гадаад нөхцлийг сайжруулж, галны халаалт, тоглоомын талбай байгуулах, орох гарах гарцанд засвар хийлгэлээ.

Мон ноос ХК-ийн угаах үйлдвэрлэлийг ажилд оруулахын тулд угаах машинд их засвар хийж, ТЭЦ -3 –аас технологийн уур авах, дулаан цахилгаан, цэвэр ус авах эрхүүдийг сэргээж ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд 40 гаруй сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгсөн.

Ариг гал ХК-ийн үйлдвэрийн барилгын 11000 метр квадрат талбайн дээврийн засварын ажлыг шинэ технологи нэвтрүүлэн өөрсдийн ажилчдын хүчээр 242 сая төгрөгөөр засвар хийлгэж хүлээн авлаа.

1990 оноос хойш ашиглалтгүй байсан бэлтгэл цехийн дээврийг засуулж 3168 м<sup>2</sup> талбайд түүхий эд, хоёрдогч түүхий эд хадгалах агуулах болгон ашиглалтанд оруулсан.

Компаний ажиллагсдын тав тухтай, цэвэр таатай орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлж, захиргааны ажилчдын 720 м<sup>2</sup>, улаанбулангийн 216 м<sup>2</sup>, ариун цэврийн 4 ш өрөө, будах, ээрэх, хялгас ялгах цехийн 3-н лабораторийн өрөө, диспетчерийн өрөө, уулзалтын өрөө, эрэгтэй эмэгтэй хувцас солих өрөө, коридорт 182 сая төгрөгийн засвар хийсэн.

Үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчийг хэвийн хангахын тулд өндөр хүчдлийн ТП – 4 –д 15 сая төгрөгийн их засвар хийж найдвартай ажиллагааг хангаж чадлаа. Технологийн хаягдал уурыг эргүүлэн ашиглахад 28 сая төгрөгийн төсөвийн ажлыг гадны мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авснаар эрчим хүчинд жилд 18 сая төгрөг хэмнэхээс гадна барилга байшингаа хамгаалах арга хэмжээг авч чадлаа.

Мон мяндас ХХК-ийн автомат, гар сүлжих, оёх цехийн ажиллах орчныг сайжруулж агааржуулалтын системийг шинээр зураг төслийг гаргуулан 200 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, монтаж засвар үйлчилгээг хүлээн авсан бөгөөд агааржуулалтын асуудлыг сайжруулан үргэлжлүүлж хийх ажиллагаа явагдаж байна.

Мон мяндас ХХК-нд 2019 оны 3-р улиралд Столл машин 4 ш, Шима машин 6 ш, нийт 10 ш автомат сүлжих машин авснаар сарын бүтээл 4200 – 5000 ширхэгээр өсч байгаатай холбогдуулан Италиас сүүлийн үеийн бүтээл өндөртэй Complete маркийн 20 ш машин, Японы Шимасейка компаниас Whole dagment маркийн оёдолгүй сүлжих машин 2 ш-г, шидээсний машин 10,8 сая төгрөгөөр авч сүлжих үйлдвэрлэлд 1 тэрбум 195 сая төгрөгийн хөрөнгө нэмж оруулснаар сүлжих үйлдвэрлэлийн хич чадал 25%-иар нэмэгдсэн байна. Компанид үр бүтээлтэй сайн ажилласан 3 ажилтны байрны урьдчилгаа 25.0 сая.төгрөгийг олгосон.

Бид урьд нь жилд 500 – 700 ширхэг загвар гаргадаг байсан бол 2019 онд 1300 гаруй загвар шинээр үйлдвэрлэлээ.

Хавт шонхор ХХК-ийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх утасны чанарыг сайжруулах зорилгоор хятадын "MX Dyeing Mashine" компаниас 50 кг,100 кг-ийн будах аппаратыг 2ш, цехийн бичил орчныг бүрэлдүүлэх, Татхам машины электрон жин, Октер 1 машины дамжуулах хэсгийн комплектоор худалдан авах зэргээр утасны үйлдвэрлэлд 289,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс гадна хялгас ялгах цехийн 30 жил ажилласан япон Торигое машины пильгарнитурыг 1 сольсон бөгөөд нийт 389 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 2018 оноос 39,1%-иар үйлдвэрлэл өссөн.

Тансаг ширээс ХХК, Эвсэг од ХХК, Мон мяндас ХХК-иудын үйлдвэрлэж байгаа бүтээгдхүүний нэр төрөл нэмэгдэж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өргөжсөн тул шулуун оёдлын 15 ш бүрэн автомат машин, нэхмэл бүтээгдхүүний хэрэглээ дэлхийн зах зээл дээр нэмэгдэж байгаатай уялдуулан нэхэх машины тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, өргөтгөх,хүчин чадлыг нэмэгдүүлэх, нарийн номерийн утсаар жин хөнгөрүүлсэн ороолт, шааль,плед гэх мэт бүтээгдхүүнийг битүү Dobi машинаар нэхэж өртөг зардлаа бууруулах бодлого барин 98 сая төгрөгийн хөрөнгө оруулж, ЕСБ компаниас Дови машин 2 ш, основ ороох машин 1 ш, СТБ машин 5 ш, хятадаас Дови машин 2 ш-г тус тус авч монтажлан шинэ бүтээгдхүүн үйлдвэрлэж, өмнөх оноос үйлдвэрлэлт 33%-иар өссөн байна.

Зөөлөн оёдлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ноолууран пальто, пиджак, майк, жилет гэх мэт бүтээгдхүүний эсгүүрийг PGM программ дээр хийж, плотерийн машинаар хэвлэж гаргаснаар оёдлын үйлдвэрлэлийн эсгүүрийн дамжлага дээр гарах өөдөс хаягдлын хэмжээг багасгаж, бүтээгдхүүний өртөг зардлыг багасгах зорилгоор эсгүүрийн туузан хутга 1 ш, хар зургийн плотер машин 1 ш, шулуун оёдлын машин 40 ш, эсгүүрийн тавцан, гадна дотор шаглаа оёх, ханцуй залгах, эсгүүрийн ширээ, энгэрийн хатуулга оёх машинаас тус бүр 1 ш, прагенератор 3 ш гэх мэт машинуудыг авч 134,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өнгөрсөн оноос зөөлөн оёдлынт үйлдвэрлэл 10,8%-иар өссөн байна.

Бүтээгдэхүүний хийц загвар, сонголт жилээс жилд нэмэгдэж Монгол улсын хувцас засварын салбарынхны хөгжил цэцэглэлтийн нүүр царайг тодорхой хэмжээгээр харуулдаг "Гоёл –

2020" наадамд амжилттай оролцож, Ерөнхий дизайнер С.Алимаа ахлагчтай загварын баг нь "Шилдэг загварын товчоо" гранпри цомын эзэн болж өнгөрсөн оны амжилтаа бататгасан нь манай хамт олон дэлхийн жишигт хүрсэн загварлаг чанартай бүтээгдхүүн үйлдвэрлэж чадаж байгааг харуулах бас баталгаа болсон байна.

Эвсэг ХХК-ийн бүтээгдэхүүнд МХХААХУАЯ, МННХ-оос "Монголын Хаан Ширхэгт" гэсэн олон улсын сертификат олгосон Монголын 2 дахь компани болсон нь манай бүтээгдэхүүн нь байгальд ээлтэй 100%-ийн эко бүтээгдэхүүн болохыг илтгэж энэхүү тэмдгийг бүтээгдэхүүний шошго,этикетик дээрээ хэрэглэх эрхтэй болсноор,компанийн ноолууран бүтээгдхүүн олон улсын зах зээлийн түвшинд үнэлэгдэх брэнд болгох үйл ажиллагааны эхлэл тавигдлаа.

#### **Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар**

"Ариг Гал" ХК-ийн удирдлагын бүтэц нь ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээр ажиллаж байгаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер холдинг ХХК иуд харъялагддаг.

Кашмер холдинг ХХК-ийн харъяанд түүний охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд орж байгаа,

Группийн харъяа компаниудаас хувьцаагаар хөрөнгө оруулалттай Мон ноос ХК, Дорнод ноос ХК-иуд нь группийн харъяалалд хамаарагдан өргөн хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулж эдгээр бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого удирдлагаар хангаж ажилладаг.

ТУЗ-ийн даргын АА нь ТУЗ-д туслах чиг үүрэгтэй бөгөөд группийн харъяа компаниудыг ТУЗ-өөс явуулж байгаа удирдлага, менежментийн бодлогыг хэрэгжүүлэх, харъяа компаниудын ажлыг дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах асуудлыг ТУЗ-ийн даргад оруулж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулахад холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, түүний дагуу компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулах зэрэг ажлыг үр дүнд хүргэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

#### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь**

Өнөөдөр тус компанийн хувьцааг өнөөдөр 7371 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байна. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшдэг.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээд

үүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон МХБ,СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн байгаа.

Компани өөрийн хувьцааны 3.2%-ийг халаасласан байна. Бусад 44.4%-ийн хувьцаа нь 7367 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа болно.

#### **Зургаа. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.**

Тус компани жил бүр 100 гаруй сая төгрөгийг ногдол ашигт зарцуулсаар ирсэн.

2018 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 32.48₮ -өөр буюу нийт 109,3 сая.төг-ийг 2020 оны 1 сард тарааж дууслаа. 2019 онд ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 19-ны өдрийн 07/20 тоот тогтоолоор баталсан 2019 оны ногдол ашгийг цэвэр ашгийн 60.0%-иар буюу нэгж хувьцаанд 38.92 төгрөг (гучин найман төгрөг 92 мөнгө)-өөр нийт 130.9 сая. төгрөг (нэг зуун гучин сая есөн зуун мянган) –өөр хуваарилахаар шийдвэрлэснийг өнөөдрийн ХЭХ-д оруулах гэж байна. Уг ногдол ашгийг 2020 оны 6 сараас хэтрүүлэхгүйгээр нийтэд зарлан тараах болно.

#### **Долоо. Цаашид хийх ажил**

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж, эргэлтийн хөрөнгийн зээл авахад нь дэмжлэг үзүүлэх.
2. "Мон ноос" ХК-ийн оффисийн барилгад засвар хийж, тогтвор сууршилтай ажиллах, залуу гэр бүл болон компанид олон жил үр бүтээлтэй үнэн ч ажиллаж буй ажилтнуудыг оруулах ажлыг эхлүүлэх.

3. "Мон ноос" ХК-ийн тоног төхөөрөмжинд иж бүрэн засвар хийж, хонины ноос угааж компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх.

4. Компанийн сул чөлөөтэй байгаа байр талбай, газрыг түрээслүүлж орлого нэмэгдүүлэх зорилгыг тавьж ажиллаж байна.

Анхаарал тавьсанд барлалаа.

**Д.Мөнхбат**- одоо Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс "Ариг гал" ХК-ний 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлье.

**2. Аудитын хоррооны гишүүн Д.Гивапил :** Хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс "Ариг гал" ХК-ний 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг танилцуулая.

**Тайлан тэнцлийн дүнгийн талаар:**

Компаний эргэлтийн хөрөнгө урьд оноос 337,6 сая төгрөгөөр буюу 0,9 хуваарь, дансны ба бусад авлага 431,3 сая төг буюу 1,2 хуваарь, биет, биет бус хөрөнгө 13,6 сая төг буюу 2,8 хуваарь тус тус өссөн бол урт хугацаат хөрөнгө оруулалт 862,9 сая төг буюу 4,1 хуваарь буурсан, нийт хөрөнгө үндсэндээ урьд оны түвшинд (522,9 сая төг, 0,9 %) актив баланстай бол пассив балансын хувьд богино хугацаат өр төлбөр 161 сая төг буюу 0,3 хуваарь, урт хугацаат өр төлбөр 430,4 сая төг буюу 67,6 хуваарь, түүний дотор НӨАТ-ын өглөг 6961,5 мян төг, бусад өглөг 56,4 сая төг, дансны өглөг 99,2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, тайлант жилийн ашиг 223,5 сая төг буюу 49,8 хуваарь харимтлагдсан ашиг 890,7 сая төг буюу 24,5 хуваарь тус тус буурсан, нийт өр төлбөр ба эзэмшигчдийн (хувьцаа эзэмшигчдийн) өмч урьд оны түвшинд (522,9 сая төг) дүнтэй тайлан баланс гарчээ. Энэ нь ажил урьд оны л хэмжээнд, харин бусдаас авах ногдол ашиг буурсан нөхцөлд компаний үр дүн, санхүү хүндрэх байдал хэвээрээ байна.

**Нэг. Орлого**

1.1 "Ариг гал" ХК-ий өөрийн үйл ажиллагааны орлого болох байрных нь түрээс 335,8 сая төг болж, урьд оноос 30 сая төг-өөр буурсан. Харин ногдол ашгийн орлого урьд онд 4,6 тэрбум төг байсан бол 2019 онд 1,6 тэрбум төг болж, урьд оноос 64,5 хуваарь буурсан.

1.2 "Ариг гал" ХК нь ямар үйл ажиллагаатай, орлогын голлох эх үүсвэр нь юу байгаа нь тайлан тэнцлээс харагддаггүй, үндсэн үйл ажиллагааны орлого гэх зүйл дээр бичсэн байрны түрээсээс гадна үндсэндээ бусдад оруулсан хувьцаагаар баталгаажсан хөрөнгийнхээ ачаар ногдол ашиг авч түүгээр санхүүжин ажиллаж, амьдардаг компани болсон, орлого өссөн, буурсан гээд үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь дүгнэх зүйл дээрхээс өөр үгүй байна.

1.3 "Ариг гал" ХК-ийн одоогийн зохион байгуулалт, бүтцээр авч үзвэл түүний охин компаниуд ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэн бие даан ажиллаж тайлан тэнцлээ өөрсдөө бие даан гарган Толгой компани болох Ариг гал ХК-даа ногдол ашиг өгч чадахгүй ажилладаг хэвээр байна.

1.4 "Ариг гал" ХК нь өөрөө 3 (гурав) охин компанитай, тэдгээр нь 6-7 охин компанитай бөгөөд тэдний ихэнхийн хувьцааг 100% ба үлэмж хэсгийг эзэмшдэг тул тэднээсээ бага ч гэсэн ногдол ашиг авдаг болвол толгой компаний үр дүн, ач холбогдол өснө. Тэхдээ тэднийхээ үр дүнг сайжруулах чиглэлээр авч буй арга хэмжээ, хөрөнгө оруулалт, төсөл нь цаашдын үйлдвэрлэл нь үр дүнд хүрэх эерэг ирээдүй байж болохоор байна. Жишээ нь: автомат сүлжих машин (Столл 4ш, Шима 6ш), өндөр бүтээлтэй Complete машин (20ш), оёдолгүй сүлжих машин (2ш), шидээсний машин (сүлжих үйлдвэрлэлд)-уудыг шинээр суурьласнаар автомат, сүлжих, оёх цехийн бүтээлийг 25 хуваарь нэмэгдүүлсэн байна. Мөн утасны чанарыг сайжруулах 50кг, 100кг-ийн будах аппарат, электрон жин, Октер машин (1ш)-ы дамжуулах хэсгийн коллектор худалдан авч тавьсан. Шулуун оёдол (15ш) бүрэн автомат машин, нарийн номерийн утсаар жин хөнгөрүүлсэн ороолт, шааль, плед бүтээгдэхүүнийг битүү нэхэх Dobi машины (2ш), Основ ороох машин 1ш, СТБ машин (5ш) тус тус монтажлан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэрлэл урьд оноос 33% өсчээ. Эсгүүрийн дамжлага дээр гарах өөдөс, хаягдлын хэмжээг багасгах эсгүүрийн туузан хутга (1ш), хар зургийн плотер машин (1ш), шулуун оёдлын машин (40ш), эсгүүрийн тавцан, гадна, дотор шаглаа оёх,

ханцуй залгах, эсгүүрийн ширээ, энгэрийн хатуулга оёх машин (тус бүрийг 1ш), прагенератор (3ш) тус тус шинээр авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр үйлдвэрлэл 21 хуваарь өссөн байна. Бүтээгдэхүүний загварыг хэрэглэгчдийн сонирхолд нийцүүлж, урьд нь жилд 500-700 загвар гаргадаг байсан бол 2019 онд 1300 гаруй загвар шинээр зохион бүтээж үйлдвэрлэсэн байна. Ийнхүү Монгол улсын хувцас загварынхны нүүр царайг харуулдаг "Гоёл 2020" наадамд "Шилдэг загварын товчоо" гранпри цом хүртсэн байна.

Техник, технологийн дээрх бүх шинэчлэл, өргөтгөл нь Ариг гал ХК-ын үйлдвэрийг цаашид өргөтгөн хөгжүүлж, орлого, ашгаа нэмэгдүүлэх суурь болоход чиглэж байна.

#### **Хоёр. Зардал**

2.1 2019 онд 735,8 сая төг-ийн үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал 66,4 сая төг, эдгээрээс цалин хөлс нийгмийн даатгалд 249,9 сая төг, зээлийн хүүд 60,4 сая төг, элэгдлийн зардал 15,3 сая төг, ашиглалтын зардалд 145,6 сая төг, бусад зардалд 174,4 сая төг тус тус зарцуулжээ. Хангамжийн материал, шуудан холбоо, албан томилолт, маркетинг сурталчилгаа, гүйцэтгүүлсэн ажил, сургалт зэрэгт зарцуулсан хөрөнгө урьд оноос нэлээд хорогдсон байна.

2.2 Энэ онд 0,8 сая төг, орлогын татвар, газрын төлбөр 120,6 сая төг, үл хөдлөх хөрөнгийн татвар 43,0 сая төг, НӨАТ 10,2 сая төг, НДШ-д 62,2 сая төг, Хүн амын орлогын татварт 29,5 сая төг тус тус улсад төлсөн байна.

2.3 Чингис хаан банкны зээлийг төлж дууссан боловч Кашмер Холдинг ХХК ашигласан 25 тэрбум төг-ийн зээлийн хүүг нь Ариг гал ХК хариуцан төлсөн байна. Гэвч урьд онуудад зээлийн хүүд 500-800 сая төг төлдөг байсан бол 2019 онд зээлийн хүүд 60,4 сая төг төлсөн нь зэрэг ажил юм.

2.4 Бусад зардалд 1030,8 сая төг байгаад валютын ханшийн зөрүү 964,4 сая төг байгаа нь валютын ханшийн алдагдал гол байрыг эзэлж байна. Тэрчлэн найдваргүй авлага 22 сая төг, (ТУЗ-ийн шийдвэртэй), буцалтгүй тусламж (ажилчдад) 7,3 сая, Шинэ жил, баярын арга хэмжээ, мэндчилгээ, шагнал урамшил 26,3 сая төг, өндөр настанд (түлш, тусламж, хандив) 9,6 сая төг зарцуулжээ.

#### **Гурав. Авлага**

3.1 Оны эцэст 36,8 тэрбум.төг-ийн авлагатай байгаа нь урьд оноос 431.3 сая төг-өөр өссөн. Энэ нь авлагын үлэмж ихэнхийг эзэлдэг. Кашмер Холдинг охин компаниас авах авлага хэвээр байгаагийн дээр статус товчоо (зээл) 75,0 сая төг, Кашмер Холдинг ХХК – 260,4 сая төг (санхүүжилт), Аргай бест (Монмьндас) 48,8 сая төг, Мон ноос 32 сая төг (санхүүжилт)-ийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна. Урьдын адил олон жил болж байгаа авлагууд хэвээрээ, авлагаа хорогдуулах талаар хийж буй ажлын үр дүн, авлага бууруулалт байхгүй байна. Авлагын комисст шилжүүлсэн 1.158,5 сая төг, СБХХ-т шилжүүлсэн 32.03 сая төг-ийн, ГЭЗХ-д шилжүүлсэн 3.010,8 сая төг-ийн авлагууд тууштай буурахгүй байна.

3.2 "Ариг гал" ХК-ий нийт авлагын дотор өөрийнх нь охин компани болох Кашмер холдинг ХК-ийн өр ихэнх (86%) нь байгаа нь түүний ажил, үр дүнг нь дээшлүүлсэн нөхцөлд авлагыг барагдуулах, багасгах боломж байгааг гэрчилнэ. Кашмер Холдинг ХХК-ий үр дүнг сайжруулах, өр барагдуулах асуудал жилээс жилд бага бага ахицтай байгаа боловч ноолууран бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх ажил удаашралттай байна.

3.3 Урьд нь өртэй байгаа, тэр нь нэлээд удаж байгаа компани, хувь хүмүүст мөнгө дахин олгодог дутагдлаа тууштай арилгахгүй байна.

3.4 Авлага барагдуулах ажлын хэсгийг ТУЗ-ийн оролцоотойгоор байгуулж, авлага нэг бүрээр дүгнэлт, тайлбар гаргуулах, дээр дурьдсан авлагыг хариуцсан газруудтай ажиллаж, дүгнэлт гаргуулах нь чухал гэж үзнэ. Ялангуяа гадаадын хамтран ажиллагчдаас авах авлагыг хөөн хэлэлцэх хугацаа алдахаас болгоомжилж, 2020 онд хүчтэй арга хэмжээ (хуулийн заалт, гэрээний нөхцлөөр) авбал зохино.

#### **Дөрөв. Өглөгийн тооцоо**

4.1 Оны эцсийн байдлаар 50,4 тэрбум төг-ийн өртэй, үүнээс дансны өглөг 47.4 тэрбум төг, татвар, цалингийн өглөг 34,1 сая төг, бусад өр 2.462,5 сая төг байна.

4.2 Санхүүгийн тайлан тэнцэлд бичсэнээр өрийн дийлэнх нь төлөгдөх хугацаандаа байгаа гэх боловч өрийн дотор бараг 10-аад жилийн өмнө үүссэн өр, хугацаа хэтэрсэн өр төлбөр байгааг барагдуулах шаардлагатай.

4.3 Ажил төрлийн холбоо бүхүй компаниудад өгөх өр нийт өглөгийн ихэнхийг (95%) эзэлж байгаа нь нэг талаас өр барагдуулах боломж зэрэг, нөгөө төлөөс нэг нь нөгөөгөө татан унгах эрсдэл байгааг анхаарвал зохино.

4.4 Бусад богино хугацаат өглөг 2,4 тэрбум байгааг ч нарийвчлан судлаж, хэрхэн барагдуулах, бүртгэл тайланд яаж тусгах зэргийг эргэж хянавал зохино. Жишээ нь: зээлийн хүүгийн тооцоонууд, хуримтлагдсан сангийн тооцооллууд гэх мэт.

#### **Тав. Бараа материалын үлдэгдэл.**

Оны эцэст Ариг гал ХК-ийн складад 31 сая төг-ийн бараа материалын үлдэгдэл байгаагийн дотор сэлбэг 15,3 сая төг, хангамжийн материал, бартерийн бараа, ноосны будаг, химийн бодис бүгд 14,4 сая төг байгаа бол Кашмер холдинг ХХК-ий агуулахад 41,2 тэрбум төг-ийн бараа материал, түүний дотор 16,3 тэрбум төг-ийн бэлэн бүтээгдэхүүн, 23,8 тэрбум төг-ийн дуусаагүй үлдвэрлэл, 975 сая төг-ийн хангамжийн материал байгаа нь дараа оны үйлдвэрлэлийн суурь болно.

#### **Зургаа. Мэдээллээр хангах үйл ажиллагаа.**

6.1 Ариг гал ХК нь хуьцаа эзэмшигчдийгээ мэдээлээр хангах зорилгоор хөрөнгийн биржийн сайтад санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ХЭХурал, ТУЗ-ийн хурлын шийдвэр зэргийг нийтэлж ажилладаг. Тайлангийн хугацаанд мэдээллийн асуудлаар санал, хүсэлт гараагүй юм байна.

6.2 Компаний аудиторуд нь дотоод хяналтыг хэрэгжүүлдэг Компани нь аудитын хяналтыг 1-р шатны аудит (тухайн үеийн байдлыг тогтоох), 2-р үе шат (анхан шатны баримтын мөрдөлт), 3-р үе шат (бүртгэл дансны хөтлөлт, гэрээ, эрх зүй, норм норматив, төсвийн мөрдөлт), 4-р үе шат (мэргэшсэн нябо, мэргэжсэн эрх зүйч, хуулийн зөвлөхийн шалгалт) гэсэн дэс дараалалтай, аль болох зөрчилгүйгээр үйл ажилгаагаа явуулахад аудитыг ашиглах зарчим баримтладаг. Гэвч дотоод хяналтын үр дүнг дээшлүүлэх, хариуцлагаа хатуу тооцох талаарх ажлыг улам сайжруулах шаардлага байна.

6.3 Цаашид аудит, хяналттай холбогдсон журмуудыг хэрэгжүүлэх ажлыг идэвхжүүлэн тогтмол болгох, эдгээр журмын хэрэгжилтийг нэгтгэн жил бүрийн санхүүгийн тайланд Компаниас зохиосон ажил, түүний үр дүнгийн хамт хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг болох нь зүүтэй гэж үзнэ.

#### **Долоо. Дүгнэлт, зорилт**

7.1 Энэхүү товч материалд дурьдсан мэдээлэл, 2019 оны тайлангийн үзүүлэлтүүдийн дүн зэргээс үзэхэд "Ариг гал" ХК-ий 2019 оны үйл ажиллагаа урьдын ижил тэр түвшиндээ л явагдаж байгаа, үйл ажиллагааны байнгын орлого, үр дүнгээ нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авах нь нэн чухал гэж үзэхээр байна.

7.2 Компаний өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, байнгын, тогтмол орлого олох үйл ажиллагаатай болох, Компаний дүрмэнд заасан инженерийн байгууламжийн үйлчилгээ, техник тоног төхөөрөмж, сэлбэг импортоор оруулж ирж худалдах, бусадтай хорших, шинэ технологи нэвтрүүлэх, хоршоо, дэлгүүр ажиллуулах, гадаад харилцааг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

7.3 Компаний гүйцэтгэх удирдлага нь үндсэн чиг үүргийнхээ дагуу ажлаа зохистой хэмжээнд явуулсан гэж үзэхээр байна.

7.4 Охин компаниудын ажил, орлого, үр дүнг дээшлүүлэх, цаашдаа ногдол ашиг хуваарьладаг болохуйц үр дүн, чадвартай компаниуд болгоход онцгой анхаарч, ялангуяа Кашмер холдинг ХХК үйлдвэрийн үр дүнг нэмэгдүүлэх, экспортийнх нь нөхцөл, төлбөр тооцоо, үнэ, зардал зэргийг цогц байдлаар судлаж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

7.5 Компаний авлага, өр төлбөрийг барагдуулах, мэдээлэл, дотоод хяналтыг сайжруулах талаар энэхүү материалд дурьдсан арга хэмжээг 2020-2021 онд тодорхой ажил болгох, урьд оноос ахиц гарсан байхаар ажиллах нь чухал.

7.6 Компаний балансын нийт активын үлэмж ихэнхийг авлага, пассив хөрөнгийн 80 гаруй

хувийг өр төлбөр, зөвхөн 16 хувийг эздийн өмч эзлэж байгаа нь Компаний тасралтгүй үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй тул эрсдлээс сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь чухал гэж үзлээ.  
Анхаарал тавьсан баярлалаа.

**Д.Мөнхбат**- ХЭ-ээс тодруулах зүйл байна. Бүх асуудлаа сонсоод санал шүүмжлэлдээ орох уу? ХЭ-ээс бүх асуудлаа сонсоод санал шүүмжлэлдээ орохоор ил саналаар шийдвэрлэв.

**Д.Мөнхбат**- За тэгвэл дараагийн асуудалдаа оръё.Одоо хэлэлцэх асуудлын дарааллаар ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдыг танилцуулна.

**3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдэд нэр дэвшигчдийн талаар** ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг ТУЗ-ийн н.б.д Л.Нямжав танилцууллаа.

**Л.Нямжав**- АГ ХК-ийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороонд өмнөх ТУЗ-д сонгогдсон 9 гишүүнээс өөр нэр дэвшигдэж орж ирээгүй байна. Тиймээс нэр дэвшүүлэх хороо нь Хараат бус гишүүнээр Б.Аюуш, Э.Бямбажав, Б.Болд нарыг, Энгийн гишүүнээр С.Мөнхжаргал, Х.Хания, Д.Мөнхбат, С.Алимаа, Б.Ёндонжамц, Д.Гивапил нарын есөн нэр дэвшигчийг ТУЗ-д сонгуулахаар шийдвэрлэсэн байна, гээд нэр дэвшигч бүрийн намтарчилсан мэдээллийг уншиж хуралд оролцогчдад танилцууллаа.

**Д.Мөнхбат**- Дараагийн асуудал нь Компанийн 2019 оны ашгаас Ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлнэ.

**4 Компанийн 2019 оны ашгаас Ногдол ашиг хуваарилах** талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа.

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 7/19 тоот шийдвэрээрээ 2019 оны цэвэр ашгийн 60%-иар, 130,98 сая.төг- (нэг зуун гучин сая есөн зуун наян мянган)-ийг хуваарилахаар шийдвэр гаргасан. Энэ нь нэгж хувьцаанд 38.92 ₮ ногдож байгаа гэсэн танилцуулга өглөө.

**Д.Мөнхбат**- Хурлын дарааллаар Компанийн удирдлагын 2020 оны зардлын төсөвийг танилцуулая,

**5. Компанийн удирдлагын 2020 оны зардлын төсөвийг** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа. Үүнд: Компанийн удирдлагын зардлын төсөв буюу АГ ХК-ийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн зардлыг 55510.0 мян.₮ (тавин таван сая таван зуун арван мянган)- өөр ХЭХ-д оруулж байна.

Энэ нь орлогыг өмнөх оноос 66.6%-иар өсгөж төлөвлөсөн. ТУЗ-ийн төсөвийг 37.9%-иар өсгөж төлөвлөж байгаа.

**Д.Мөнхбат**- Хэлэлцэх асуудлын дарааллаар компанийн шинэчилсэн дүрмийн төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцуулна.

**6. Компанийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төслийг** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа.

Тус компанийн оршин байрлах хаяг нь ХУД-ийн 15-р хороо гэж байсан. Харин хорооны харъяалал 19-р хороо болж өөрчилөгдсөн тул улсын бүртгэлийн хуулийн дагуу хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгаж шинэчилсэн найруулга хийсэн байгаа гээд дүрмийн 1-р бүлгийг танилцуулав.

**Д.Мөнхбат**- Хэлэлцэх асуудлыг танилцуулж дууслаа. Одоо санал шүүмжлэлдээ оръё.

**М.Гөлгөө**-Манай нийгэмлэг хувьцааны 19.99%-ийг эзэмшиж байгаа. АГ ХК нь ноолуурын үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийсний үр дүнд экспорт болон дотоодын борлуулалтыг өсгөх нөхцөл хангагдсан гэж ойлгож явдаг. Тайлангаас харахад ноолуурын үйлдвэрлэлд оруулсан зээлийн эргэн төлөлт удаашралтай харагдаж байна. Энэ жилийн хувьд олон улсад хөл хорио тогтоосон, ялангуяа төлөлт улам хүндрэх нь ойлгомтой боллоо.

Нөгөө талаас хувьцаа эзэмшигчийн хувьд ч ноолуурын салбарыг сайн мэддэг хүний хувьд ч салбарын яамны түүхий эдийн бодлогод маш сэтгэл дундуур явдаг. Энэ талаар яамандаа асуудлаа тавьж шийдвэрлүүлсэн асуудал байна уу?

**Дэд захирал А.Төмөрочир**- Маш зөв асуудал хөндлөө. Миний хувьд яг энэ түүхий эдийн бэлтгэл дээр ажилладаг хүний хувьд хэлэхэд яамны бодлого маш буруу явсан. Хэдийгээр компанид хөнгөлөлттэй зээл олгоно гэж байгаа болов ч тэр нь хугацааны хувьд асуудалтай, нөгөө талаар нэг талдаа 100.0 мян₮-өөр ноолуур аваад, нөгөө талдаа хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтээ хийлээ гэхэд түүхий эдийн үнийн 30%-нь компанид алдагдал болж байгаа.

Тиймээс компанийн хувьд аль болох дотоод бололцоогоо дайчлах асуудал тулгарч байгаа. Манай хувьд гэхэд тодорхой хэмжээний эзэмшил газрын эзэмших эрхийг бусдад худалдах шийдвэрийг ТУЗ-өөр гаргуулаад санхүүгийн эх үүсвэр гаргах, өөр бизнесийг эхлүүлэх судалгааны ажлын эхлүүлээд явж байгаа.

**Ё.Дарьдулам**- Ногдол ашгийг хэзээ олгох вэ?

**ТУЗ н.б.д Л.Нямжав**- СЗХ-ны мэдэгдэл ирсэн 6 сараас өмнө бүх НА-ыг тараасан байх үүрэг өгөгдсөн байгаа. Тиймээс манайх 6-р сард багтааж НА-ыг тараана.

**Д.Мөнхбат**-Өөр санал шүүмжлэл гаргах Хувьцаа эзэмшигч байна уу? гэхэд санал шүүмжлэл гаргах Хувьцаа эзэмшигч алга гэснээр санал шүүмжлэлийг хаалаа.

**Д.Мөнхбат**-За одоо тооллогын комисс дүнгээ мэдээлье.

**Тооллогын комиссын дарга Ч.Энхцэцэг**- ХЭХ-ын тооллогын дүнг танилцууллаа.

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Шийдвэрлэсэн нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн 2886994 санал буюу 100.0%-ийн саналаар "Ариг гал" ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайланг батлав.

2. Хувьцаа эзэмшигчдийн 2886994 санал буюу 100.0 %-ийн саналаар "Ариг гал" ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлав.

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив 2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Б.Ёндонжамцыг, 2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Д.Мөнхбатыг, 2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар С.Алимааг, 2886989 санал буюу 16.67%-ийн саналаар Д.Гиваапилийг, 2886989 санал буюу 16.67 %-ийн саналаар Х.Ханияг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,

Кумулятив 2886989 санал буюу 33.33 %-ийн саналаар Б.Аюушийг, 2886989 санал буюу 33.33 %-ийн саналаар Э.Бямбажавыг, 2886989 санал буюу 33.33%-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгож батлав.

4 Хувьцаа эзэмшигчдийн 2886994 санал буюу 100.0 %-ийн саналаар Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 7/19 тоот шийдвэрийн дагуу 2019 оны цэвэр ашгийн 60%-иар, 130,98 сая.төг- (нэг зуун гучин сая есөн зуун наян мянган)-ийг буюу нэгж хувьцаанд 38.92 ₮-ийг хуваарилахаар шийдвэрлэв.

5. Хувьцаа эзэмшигчдийн 2886981 санал буюу 100.0 %-ийн Ариг гал ХК-ийн 2020 оны удирдлагын зардлын төсөвийг 55510.0 мян.₮ (тавин таван сая таван зуун арван мянган)- өөр баталлаа.

6. Хувьцаа эзэмшигчдийн 2886981 санал буюу 100.0 %-ийн Ариг гал ХКомпанийн "ХУД. 19-р хороо. Зайсан гудамж. Үйлдвэрийн парк 18-01 тоот" гэсэн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийг батлав.

7. Хурлаас гарсан шийдвэрийн төслийг хуралд оролцсон гишүүдийн ил саналын 2025283 санал буюу 58,2% -ийн саналаар батлав.

**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:**

**ХУРЛЫН ДАРГА**

**Тооллогын комиссын дарга**

*Б.Тугуу*

**Б.МӨНХТУУЛ**



**Д.МӨНХБАТ**

**Ч.ЭНХЦЭЦЭГ**